

ТӨРИЙН АРХИВУУДЫН 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2018 оны 04 дүгээр сарын 20

Улаанбаатар хот

МУ-ын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам”, Архивын ерөнхий газрын даргын 2017 оны А/144 дүгээр тушаалаар баталсан “Төрийн архивын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг тус тус үндэслэн аймаг, нийслэл, салбар, төрөлжсөн архив /цаашид төрийн архив гэнэ/-ын 2017 оны үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ хийлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ нь төрийн архивын стратеги зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, үр дүнг шинжлэн дүгнэх, 2017 онд хэрэгжүүлсэн ажлын тайлан, статистик мэдээг нэгтгэх, цаашид анхаарах асуудлын талаар зөвлөмж өгөхөд чиглэгдсэн.

Хяналт-шинжилгээг хийхдээ төрийн архивын бичвэр тайланг тухайн архивын ерөнхий мэдээлэл, үйл ажиллагааны төлөвлөлтийн талаарх мэдээ, үндсэн үйл ажиллагааны 9 үндсэн үзүүлэлт бүхий статистик мэдээний хамт гаргуулан авч “Төрийн архивын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-д заасан чиглэлүүдээр ангилан үзэж үнэлгээ хийсэн болно.

Нэг. Төлөвлөлт, удирдлага, зохион байгуулалтын талаар

1.1. Төрийн архивын үйл ажиллагааны төлөвлөлтийн талаар:

Төрийн архивууд нь 2017 оны үйл ажиллагаандаа Архивын тухай хууль, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Хууль зүй, дотоод хэргийн сайдын аймаг, нийслэлийн Засаг дарга нартай тухайн онд байгуулсан Хамтран ажиллах гэрээ, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр, Төрийн архивын ажлын үндсэн заавар болон холбогдох заавар, журмуудтай уялдуулан ажлаа төлөвлөж хэрэгжүүлэн ажилласан байна.

Архивууд нь 2017 оны үйл ажиллагаагаа төлөвлөхдөө архивын баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулах, баримтын мэдээлэл, эрэлт хайлтыг боловсронгуй болгох, сан хөмрөгөө нөхөн бүрдүүлэх болон баримтыг цахим хэлбэрт оруулах ажлыг эрчимжүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, ажилтнуудаа сургаж бэлтгэх, мэргэшүүлэх зэрэг зорилт тавьж ажиллажээ.

Дээр дурдсан хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, гэрээтэй уялдуулан 2017 оны үйл ажиллагаандаа нийт архивууд 1388 арга хэмжээ төлөвлөснөөс 1367 арга хэмжээг хэрэгжүүлсэн бөгөөд 21 арга хэмжээний хэрэгжилтийг тодорхой шалтгааны улмаас хойшлуулсан байна.

Нийт төрийн архивуудын төлөвлөгөөний биелэлт 94,6 хувьтай байгаа нь өмнө оны үзүүлэлтээс 0,5 хувиар өссөн байна.

Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хүснэгтээр харуулбал:

Д/д	Архивын нэр	2016 он			2017 он		
		Төлөвлөсөн арга хэмжээ	Гүйцэтгэл	Хувь	Төлөвлөсөн арга хэмжээ	Гүйцэтгэл	Хувь

1	Нийт 36 архив	1429	1346	94,1	1388	1367	94,6
2	2017 оноос өссөн /+/, буурсан /-/ дүн/Төлөвлөсөн арга хэмжээний тоо/				-41	+21	+0,5

Мөн аймгийн архивууд нь ХЗДХ-ийн сайдаас аймгийн Засаг дарга нартай байгуулсан Хамтран ажиллах гэрээнд архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр 2-5, Нийслэлийн архивын газар 4, ОӨУБЕГ-ын Төв архив 2 арга хэмжээг тусгаж ажилласан бөгөөд гэрээнд тусгаж ажилласан байна.

Дээрх гэрээнд аймгийн архивууд 2017 онд үндсэн 5 чиглэлээр арга хэмжээ тусгаж, дараах ажлуудыг хэрэгжүүлэн ажиллажээ.

1. *Архивын баримт бичгийн 30 хувийг цахим хэлбэрт шилжүүлж төрийн албан хэрэг хөтлөлтөд тоон гарын үсэг нэвтрүүлэх, мэдээллийн нэгдсэн систем бүрдүүлэх замаар төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг сайжруулах*

Энэ арга хэмжээг Архангай, Говь-Алтай, Орхон, Өвөрхангай, Сэлэнгэ, Хөвсгөл аймгийн архивууд гэрээндээ тусгасан бөгөөд биелэлтийг ирүүлэхдээ энэхүү тайлангийн 2.7-т заасан /Мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэлт, цахим хувь үйлдсэн байдал/ гэсэн хэсэгт дурдсан цахим хэлбэрт шилжүүлсэн архивын баримтын тоо хэмжээний талаар тусган ирүүлсэн.

2. *“Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх” үндэсний хөтөлбөрийг эрчимжүүлэх зорилгоор аймаг, нийслэлийн төрийн архивын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг сайжруулах, архивын баримтыг цахимжуулж буй гэрээт архивч-операторчийн тоог нэмэгдүүлэх чиглэлээр шат дараатай арга хэмжээ авах*

Энэ арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлсэн ажлыг гэрээт архивч-операторчийн тоог нэмэгдүүлэх болон техник, тоног төхөөрөмж сайжруулах гэсэн чиглэлээр хуваан авч үзсэн. 2017 онд аймгийн архивуудад нийт 22 гэрээт архивч-операторч нэмж ажиллуулан орон нутгийн төсөв болон дотоод орлогоос цалинжуулсан байна.

3. *Аймаг, нийслэлийн төрийн архивт хадгалагдаж байгаа Монгол улсын Ерөнхийлөгч, УИХ, Орон нутгийн ИТХ-ын сонгуульд холбогдох баримтыг цэгцэлж, 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн баримтыг хүлээн авах бэлтгэл ажлыг хангах*

Аймаг, нийслэлийн төрийн архивт хадгалдагдаж байсан Монгол улсын Ерөнхийлөгчийн 2013 оны сонгуулийн баримтыг холбогдох заавар, журам, Сонгуулийн ерөнхий хорооноос хүргүүлсэн албан бичгийн дагуу саналын хуудсыг устгаж, 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн баримтыг хүлээн авах бэлтгэл ажлыг хангасан байна.

4. *Архивын байр, хадгаламжийн сангийн зай талбайг нэмэгдүүлэх, архивын зориулалттай нягтруулсан тавиур шүүгээгээр хангах, архивын баримтын хадгалалт, хамгаалалтын орчин, нөхцлийг сайжруулах чиглэлээр шат дараатай арга хэмжээ авах*

а/ Архивын байр, хадгаламжийн сангийн зай талбайг нэмэгдүүлэх чиглэлээр

-Булган, Орхон аймгийн архивын тасаг 2017 онд шинэ байранд орж, стандартад нийцүүлэн тохижуулах, шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангахад тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн.

-Баянхонгор аймаг төрийн архивын хадгаламжийн талбайн хэмжээг 40м²-аар, Говь-Алтай 38,2м²-аар, Дархан-Уул 49м²-аар, Өвөрхангай 3 өрөө нэмэгдүүлж, архивын байрны тохижилт, гадна фасадны засвар хийж орчин нөхцлийг сайжруулсан, ЦЕГ-ын төв архив, Сэлэнгэ аймгийн архивууд Үзэсгэлэнгийн болон Уншлагын танхимыг байгуулсан байна.

б/ Архивын зориулалттай нягтруулсан тавиур шүүгээгээр хангах, архивын баримтын хадгалалт, хамгаалалтын орчин, нөхцлийг сайжруулах чиглэлээр

5. Төрийн архивын сан хөмрөгт хадгалагдаж буй хосгүй үнэт баримтыг илрүүлж бүртгэлжүүлэх

Аймаг, нийслэлийн төрийн архивууд нь сан хөмрөгөөс Хосгүй үнэт баримт илрүүлэх ажлыг зохион байгуулж, Хосгүй үнэт баримт гэж үзсэн баримтуудын жагсаалтыг үйлдсэн байна.

Төрийн архивууд нь үндсэн үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс гадна 2017 онд МУ-д болон аймгуудад архивын алба үүсэн байгуулагдсаны ойн арга хэмжээний хүрээнд тусгайлсан төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллажээ.

Ойн арга хэмжээний хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулсан байна.

АЕГ-аас хүргүүлсэн чиглэлийн дагуу нийт архивууд “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг зохион байгуулсан бөгөөд уг арга хэмжээний үеэр архивын лавлагаа хуулбарыг үнэ төлбөргүй олгох, бичил үзэсгэлэн гаргах, үйлчилгээний талаар санал асуулга авах зэрэг арга хэмжээг зохион байгуулсан байна.

Төрийн архивууд нь ойг тохиолдуулан Эссэ бичлэгийн уралдаан, АХА тэмцээн, ажил мэргэжлийн ур чадварын уралдаан, спортын тэмцээн, танин мэдэхүйн цэнгээнт нэвтрүүлэг, бүтээлч ажил, болзолт уралдаан зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулсан байна.

АЕГ-аас болон тухайн архиваас санаачлан зохион байгуулсан урлаг, спортын наадам, ажил мэргэжлийн уралдаанд нийт төрийн архивуудын ажилтнууд болон тэдгээрийн хөмрөг үүсгэгч байгууллагын архив, бичиг хэргийн ажилтнуудыг идэвхитэй оролцуулснаас гадна дээрх арга хэмжээний талаар тухай бүр улсын хэмжээний болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилжээ.

Мөн ойг тохиолдуулан ажил, хөдөлмөрөөрөө манлайлан ажилласан ажилтнуудаа төрийн болон яам, агенлаг, орон нутгийн шагналаар шагнуулсан байна.

Төрийн архивын дарга /эрхлэгч/ нар ажлаа төлөвлөхдөө өөрийн хүний нөөц, техник, тоног төхөөрөмжийн хүрэлцээ зэргийг харгалзан төлөвлөж эрх бүхий албан тушаалтнаар батлуулах, төлөвлөгөөний биелэлтэд тухай байгууллагын Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжээр дүгнүүлж, тухайн дүнг ирүүлж байх, “Төрийн архивын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын хавсралтад заагдсан баримт бичгүүдийн хүрээнд төлөвлөж гүйцэтгэсэн ажлын биелэлт, ХЗДХ-ийн сайдтай байгуулсан гэрээний биелэлт зэргийг журамд болон албан бичигт заасан хугацаанд ирүүлж байх шаардлагатай байна.

1.2. Засгийн газрын тогтоолоор батлагдсан Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт:

МУ-ын Засгийн газрын 2017 оны 04 дүгээр тогтоолын 04 дэх заалтын дагуу ХЗДХ-ийн сайдаар Үндэсний хөтөлбөрийн дөрөвдүгээр үе шатанд гүйцэтгэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан холбогдох яам, агентлаг, аймгийн ЗДТГ, төрийн архивуудад хүргүүлж, төлөвлөгөөний биелэлтэд АЕГ-аас хяналт тавьж ажилласан бөгөөд төрийн архивууд цахим хэлбэрт шилжүүлсэн баримтын статистик мэдээг сар бүр АЕГ-т ирүүлж, шаардлагатай мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө авч ажиллажээ.

Хоёр. Төрийн архивын үндсэн үйл ажиллагааны талаар

2.1. Мэргэжил арга зүй, сургалтын талаар

Тайлант хугацаанд төрийн архивууд хөмрөг үүсгэгч байгууллага /нэгжүүд/-д 3240 удаа арга зүйн зөвлөгөө өгч, 701 удаа сургалт зохион байгуулжээ.

Аймгийн архивуудаас хөмрөг үүсгэгч байгууллагад зохион байгуулсан сургалтын тоогоор Говь-Алтай 78, Баян-Өлгий 54, Сэлэнгэ 37, Хөвсгөл 28, Өмнөговь 27 гэсэн

үзүүлэлтээр тэргүүлж байгаа бөгөөд Орхон 2, Хэнтий, Увс 3, Архангай 4 гэсэн үзүүлэлттэй байна.

Харин Үндэсний төв архив, Нийслэлийн архив, салбар, төрөлжсөн архивуудаас Нийслэлийн архивын газар 124, ШШГЕГ-ын архив 51, ЦЕГ-ын Төв архив 48, БХТА 41 гэсэн үзүүлэлттэй байсан бол ҮТА, ГХТА, Геологийн мэдээллийн төв, Шүүхийн төрөлжсөн архив зэрэг архивууд 1 удаа сургалт зохион байгуулсан гэж мэдээ ирүүлжээ.

Төрийн архивын дарга /эрхлэгч/ нар нь хөмрөг үүсгэгч байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудаас судалгаа авсны үндсэн дээр анхан шатны болон мэргэшүүлэх сургалтад ажилтнуудаа хамруулсан байна. Тус сургалтад төрийн архивууд нийт 5529 ажилтнуудыг хамруулсан бөгөөд Нийслэлийн архив давхардсан тоогоор 4279, УЦУОШГ-ын архив 58, Төмөр замын архив 53, Баянхонгор 607, Төв 46, Сэлэнгэ, Өмнөговь 34 ажилтныг сургалтад хамруулсан үзүүлэлтээр тэргүүлж байна.

Төрийн архивуудын зохион байгуулсан мэргэжил, арга зүйн сургалт :



2016 онд хөмрөг үүсгэгч байгууллагад зохион байгуулсан сургалтын тоо нь 2313 байсан бол 2017 онд 701 удаа зохион байгуулж 1612-оор буурсан боловч сургалтад хамрагдсан ажилтны тоо 1238-аар буюу буюу 22.4 хувиар өссөн үзүүлэлт гарчээ.

Дээр үзүүлэлтээс харахад сургалтад хамрагдсан ажилтнуудын тоо өссөн нь байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа, архивын баримтыг цахимжуулалтын чанар, түвшин дээшлэхэд нөлөөлнө гэж үзэж байна.


2.2. Архивын сан хөмрөгийн нөхөн бүрдүүлэлт, нягтлан шалгалт

Архивын тухай хуулийн 21 дүгээр зүйл, ТААҮЗ-ын 3.1.4-т зааснаар “Архивын сан хөмрөгийг нөхөн бүрдүүлэх үндсэн болон боломжит эх үүсвэрийн жагсаалт”-ыг АЕГ-ын дэргэдэх ББНШТК-ын хурлаар батлуулж уг жагсаалтын дагуу хуваарь гарган хөмрөг үүсгэгч байгууллаас баримтаа шилжүүлэн авсан байна.

Төрийн архивууд нь өөрсдийн онцлогоос хамааран 2-1045 байгууллага /хөмрөг үүсгэгч/-ын баримтаар сан хөмрөгөө нөхөн бүрдүүлжээ.


Нийт төрийн архивууд 1716 байгууллага, иргэдийн баримтаар сан хөмрөгөө нөхөн бүрдүүлснээс төрийн 879, төрийн бус 797 байгууллага, 40 иргэний баримтыг хүлээн авчээ.

Графикаар харуулбал:



2017 онд төрийн архивууд сан хөмрөгөө нийт 394575х.н баримтаар нөхөн бүрдүүлснээс удирдлагын 71268 хн, зураг төслийн 16888 хн, гэрэл зургийн 21146, тусгай төрлийн 227407, бусад 6031 хадгаламжийн нэгжээр тус тус сан хөмрөгөө нөхөн баяжуулжээ.

Нөхөн бүрдүүлсэн баримтын төрлийг графикаар харуулбал:



Аймаг, нийслэлийн архивууд төлөвлөгөө, хуваарийн дагуу нөхөн бүрдүүлэлтээр бүх төрлийн баримт хүлээн авснаас гадна МУ-ын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуульд холбогдох баримт /саналын хуудас, холбогдох бусад баримт/-ыг хүлээн авч архивын заавар журмын дагуу цэгцэлж, сан хөмрөгт байршуулсан байна.

Баянхонгор, Хөвсгөл, Дорноговь, Завхан аймгийн архивууд 45-156 байгууллагын баримтаар нөхөн бүрдүүлснээр тэргүүлсэн бол Ховд, Дархан-Уул, Говьсүмбэр, Архангай аймгийн архивууд 3-6 байгууллагын баримтаар нөхөн бүрдүүлсэн байна.

Баянхонгор, Дорноговь, Сэлэнгэ, Хөвсгөл, Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн төрөлжсөн аймгийн архивууд нь захирамжлалын баримтыг цаасан болон цахим хэлбэрээр авч хэвшиж байгаа бөгөөд Хөвсгөл аймгийн архив нь “Гүйцэтгэлийн хуудас” боловсруулан уг хуудасны дагуу нөхөн бүрдүүлэлт, баримтыг цахим хэлбэрт шилжүүлсэн байдалд үнэлэлт өгч ажилласнаар ажлын үр дүн сайжрах ач холбогдолтой болсон байна.

2016 онд аймаг, нийслэлийн архивт 70 хөмрөг шинээр нэмэгдэж байсан бол 2017 онд аймгийн архив 86 хөмрөг шинээр нэмэгдсэн бөгөөд өмнөх оныхоос 16 хөмрөгөөр илүү байгаа нь архивын баримтын нөхөн бүрдүүлэлт нэмэгдэж байгаа нь харагдаж байна.

Нийт архивууд нь хөмрөг үүсгэгчээс баримт хүлээн авахдаа Төрийн архивын ажлын үндсэн зааврын 3.2.1-т “нөхөн бүрдүүлэх үндсэн эх үүсвэр болох байгууллагын баримтыг бүрэн хэлбэрээр хүлээн авна” гэж заасныг сайтар мөрдөж ажиллах нь зүйтэй. Мөн архивуудын тухайн онд нэмэгдсэн баримтын тоо хэмжээний өсөлт нь нөхөн бүрдүүлэлтээр хүлээн авсан баримтын тоотой харьцуулахад зөрүүтэй байгаа нь бодит

тоон мэдээ нэгтгэн гаргах, удирдлага болон дээд шатны байгууллагыг мэдээ, мэдээллээр хангахад тоон мэдээ бодитоор гарахгүй болох учир энэ талаар анхаарах шаардлагатай байна.

2.3. Архивын баримтын нягтлан шалгалт, дахин боловсруулалтын талаар

Нийт төрийн архивууд 2134 хөмрөг, 2252 данс, 4005216 хадгаламжийн нэгжид иж бүрэн нягтлан шалгалт хийсэн байна. Энэ үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулахад бүх үзүүлэлт /хөмрөг, данс, хадгаламжийн нэгж/-ээр өссөн байна.

Төрийн архивуудын нягтлан шалгалт хийсэн баримтын хэмжээ:

Д/д	Архивын нэр	2016 он			2017 он		
		Хөмрөгийн тоо	Дансны тоо	Х.н-ийн тоо	Хөмрөгийн тоо	Дансны тоо	Х.н-ийн тоо
1	Төрийн архивууд	1353	1220	339586	2134	2252	4005216
2	Өссөн /+/, буурсан/-/ дүн	Хөмрөгийн тоо /+781/		Данс /+1032/		Х.н-ийн тоо /+3665630/	

Жил бүрийн тоон мэдээ, тайлангаас харахад төрийн архивууд нь нягтлан шалгалт, дахин боловсруулалтын ажлыг өөрсдийн хүний нөөцийн боломжоос шалтгаалан харилцан адилгүй тоогоор хийсэн байна. Зарим архивуудын орон тооны хувьд цөөн, зааварлагч арга зүйч байдаггүй, ажилтнууд лавлагаа, хуулбар олгох, баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх зэрэгт ихээхэн цаг хугацаа зарцуулдаг зэргээс нягтлан шалгалтын ажил бага хийгдэж байна.

2017 онд төрийн архивуудын дэргэдэх Баримт Бичиг Нягтлан Шалгах Арга Зүйн Комисс /цаашид БНШАЗК гэх/-ын хурал 131 удаа хуралдаж, 2022 асуудлыг хэлэлцсэн бөгөөд 2016 /126 удаа хуралдаж, 2041 асуудал/ онтой харьцуулахад хуралдсан тоо 5-аар нэмэгдэж, хэлэлцсэн асуудлын тоо 19-өөр буурсан байна. Үүнээс харахад хурлын тоо нэмэгдэж, хэлэлцсэн асуудлын тоо цөөрсөн нь комиссын хурлын чанар харьцангуй дээшилсэн гэж үзэж болохоор байна. Гэвч нэг удаагийн хурлаар 20-61 асуудал хэлэлцэн шийдвэрлэж байгааг анхаарах нь зүйтэй.

БНШАЗК-ын хурлаар хэлэлцсэн асуудал дүн тоог графикаар харуулбал:



Цаашид комиссын хурлаар хэт олон асуудлыг нэг удаагийн хурлаар хэлэлцүүлэхгүй байх, тухай бүр тогтмол хуралдуулах, комиссын гишүүдэд архив, албан

хэрэг хөтлөлтийн чиглэлээр дадлага туршлагатай ажилтнуудыг оролцуулж байх, асуудал бүрийг нэг бүрчлэн хэлэлцэж шийдвэрлэхэд анхаарах нь зүйтэй.

2.4. Архивын баримтын тоо бүртгэл, тооллого, эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны сан бүрдүүлэлт

Нийт төрийн архивууд Архивын тухай хуулийн 15.1.7 дахь заалт, Төрийн архивын ажлын үндсэн зааврын 4.3.4, 4.3.6, 4.5.1, 4.5.2 дахь заалтын дагуу нийт архивууд баримтын тооллого хийсэн байна. 2017 онд төрийн архивууд 1885 хөмрөгийн баримтанд сэдэвчилсэн болон хэсэгчилсэн тооллого хийжээ.

Тайлангийн хугацаанд төрийн архивууд нь 420 данс шинээр, 663 данс шинэчлэн үйлдсэнээс аймгийн архивууд шинээр 382, шинэчлэн 329, УТА, Нийслэл, салбар, төрөлжсөн архивууд шинээр 38, шинэчлэн 334 данс үйлдсэн бөгөөд Баянхонгор 164, Баян-Өлгий 23, Хөвсгөл 17, Говьсүмбэр 15, Сэлэнгэ 14 шинээр үйлдсэн нь аймгуудын архивуудаас тэргүүлсэн бөгөөд Булган, Орхон, Ховд аймгийн архивууд шинээр данс үйлдээгүй гэж мэдээндээ тусгажээ.

Төрийн архивууд 2017 онд төрийн архивууд нийт 186056 баримтад тооллого хийсэн байна.

Төрийн архивын тооллого хийсэн х.н-ийн тоо:

Д/д	Архивын нэр	Тооллого хийсэн хадгаламжийн нэгжийн тоо	
		2016 он	2017 он
1	Төрийн архивууд	4191786	186056
2	Өссөн /буурсан/ дүн	-4005730 хадгаламжийн нэгжээр	

2.5. Архивын баримтын хадгалалт хамгаалалт

Архивын тухай хуулийн 15.1.3 дахь заалт “Архивын баримтыг зориулалтын байранд зохих горимын дагуу хадгалах”, 19.7 дахь заалт “Төрийн архивын баримтыг зориулалтын байранд тусгай тавиур шүүгээнд хадгална”, Төрийн архивын үндсэн зааврын 5.2 дахь заалтад заасан “архивын байр, түүнд тавигдах шаардлага”-ыг хангах чиглэлээр төрийн архивууд нь дараах арга хэмжээг авч ажилласан байна.

Архивууд нь 2017 онд нийт 87393 баримтын шинж чанарт үзлэг хийснээс удирдлагын 35567, зураг төслийн 3545, гэрэл зургийн 44159, тусгай төрлийн 28723, баримтад үзлэг хийсэн байна.

Төрийн архивууд нь архивын байр, тавиур шүүгээ, хадгалалт хамгаалалтын чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажилласан байна


Архивын байр хадгалалт хамгаалалтыг сайжруулах талаар дээр дурдсан арга хэмжээнээс гадна баримтын хамгаалалтын хайрцаг авах, галын дохиоллын систем, камер суурилуулах, галын хорыг шалгаж, цэнэглүүлэх, тоог нэмэгдүүлэх, дулаан, чийгшилтийн горимыг алдуулахгүй байх, ариутгал хийлгэх, албан ёсны лицензтэй вирусын эсрэг программ суулгах зэргээр анхаарч ажиллажээ.

Гадаад харилцааны төв архив нь архивын мэдээллийн санг боловсронгуй болгох, аюулгүй байдлыг хангах, техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх зорилгоор БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллагыг санхүүжилтээр төсөл хэрэгжүүлэхээр шийдвэрлүүлсэн, НАГ нь сэлбэн засах, сэргээн шинэтгэх лаборатори байгуулах талаар төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа, Дорноговь аймгийн архив баримтыг сэлбэн засах сэргээн шинэтгэхэд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн төсвийг шийдвэрлүүлсэн зэргээр ажлуудыг хэрэгжүүлжээ.

2.6. Эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны сан бүрдүүлэлт


Архивын эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны сан бүрдүүлэлтийн ажлыг Архивын тухай хууль болон Төрийн архивын ажлын үндсэн зааврын 6.1-д заасан шалгуурын дагуу сан хөмрөгт хадгалагдаж байгаа баримтын болон шинээр хүлээн авсан баримтын эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны санг иж бүрэн бүрдүүлэх ажилд анхаарч ажилласан байна.

Эрдэм шинжилгээний лавлах үйлдсэн байдлыг графикаар харуулбал:



Аймгийн архивууд нь 711 данс, 413 танилцуулга, 1405852 заагч үйлдсэн бол ҮТА, нийслэлийн архив болон төрөлжсөн, салбар архивууд 372 данс, 299 танилцуулга, 3480 заагч үйлдсэн байна.

Бичсэн танилцуулгыг графикаар харуулбал:



Үйлдсэн заагчийн тухайд: 2016 онд нийт 694103 заагч үйлдэж байсан бол 2017 онд 1405852 заагч үйлдсэн байна.

2.7. Мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэлт, цахим хувь үйлдсэн байдал

Төрийн архивууд 2017 онд 687 хөмрөгийн 799 дансны 26313 хадгаламжийн нэгжийг программд тодорхойлон бичиж оруулсан бөгөөд 6158 хөмрөгийн баримтыг иж бүрэн үүсгэж ашиглалтад шилжүүлсэн байна.

Нийт төрийн архивууд 1088 хөмрөгийн 964 дансны 92902 хадгаламжийн нэгжийн 28729709 хуудас баримтыг сканердаж, 760 хөмрөгийн 751 дансны 36190 хадгаламжийн нэгжийн 22013372 хуудас баримтад ашиглалтын хувь, 750 хөмрөгийн 804 дансны 45730 хадгаламжийн нэгжийн 22144190 хуудас баримтад мастер хувь үйлдэж, 927 хөмрөгийн 809 дансны 77789 хадгаламжийн нэгжийн 22941296 хуудас баримтыг программд холболт хийжээ.

2.8. Архивын баримтын ашиглалт, мэдээлэл лавлагаа

Төрийн архивууд нь Архивын тухай хууль, Төрийн архивын ажлын үндсэн заавар, Төрийн архивын баримт ашиглалтын нийтлэг журам болон холбогдох заавар, журмыг хэрэгжүүлэн ажилласан бөгөөд 2017 онд 90-н жилийн ойн арга хэмжээний хүрээнд Нээлттэй хаалганы өдөрлөгийг нийт архивууд тус бүр 2-3 удаа, өөрийн сан хөмрөгт хадгалагдаж буй баримтад тулгуурласан үзэсгэлэнг 1-13 удаа зохион байгуулжээ.

2017 онд төрийн архивууд нь 200444 иргэд, байгууллагад үйлчилгээ үзүүлж 345116 лавлагаа, хуулбар олгож үйлчилсэн байна.

2016 онд 559944 хадгаламжийн нэгж ашиглаж 306131 лавлагаа хуулбарыг иргэд байгууллагад олгож байсан бол 2017 онд 653545 хадгаламжийн нэгж ашиглаж 345116 лавлагаа хуулбарыг иргэд байгууллагад олгож, олгосон лавлагаа хуулбарын тоо нэмэгдсэн байна. Энэ нь архивын байгууллагаар үйлчлүүлэгч иргэд, байгууллагын тоо нэмэгдсэнтэй холбоотой бөгөөд архиваас олдоогүй гэсэн лавлагааны тоо буурсан нь баримтыг цахим хэлбэрт шилжүүлснээр баримтын хайлт /үйлчилгээний чанар/ сайжирсан гэж үзэж болохоор байна.

ҮТА, Нийслэлийн архивын газар, ХХЕГ-ын төв архив, Дорноговь аймгийн архивууд нь архивын лавлагаа хуулбар олгох үйл ажиллагаанд Тусгай нууцлал бүхий цаасыг хэвлүүлэн ашигласан, ажилтнуудад хувийн дугаар олгосон зэргээр ашиглалт мэдээллийн үйлчилгээндээ анхаарч ажиллажээ.

Гурав. Дүгнэлт

Төрийн архивуудын 2017 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээс харахад төлөвлөгөөний биелэлт нийт төрийн архивын хэмжээнд дунджаар 94,6 хувьтай, энэ нь өмнөх оны 94,1 хувьтай харьцуулахад 0,5 хувиар өссөн, нийт арга хэмжээний биелэлтийн дундаж 89,8 хувьтай гарсан бөгөөд өмнөх оны 89,0 хувь харьцуулахад 0,8 хувиар өссөн үзүүлэлттэй гарсан бөгөөд “Хангалттай” сайн гэж дүгнэж байна.

Нийт төрийн архивууд нь 2017 онд үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллахаас гадна МУ-д орчин цагийн архивын алба үүсэн байгуулагдсаны 90-н жил, зарим аймгийн архивууд орон нутагт архивын алба үүсэн байгуулагдсаны 60-н жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг тодорхой төлөвлөгөө гаргаж амжилттай зохион байгууллаа. Мөн АЕГ-аас санаачлан зохион байгуулсан урлаг, спорт, ажил мэргэжлийн тэмцээн, уралдаанд төрийн архивын болон хөмрөг үүсгэгч байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтнуудыг идэвхитэй оролцуулсан.

Архивуудаас ирүүлсэн тайландаа Архивын тухай хуулийг шинэчлэн батлуулах, архивын байрны багтаамж, орон тоо, хүний нөөц дутагдалтай, цалин хангамжийг нэмэгдүүлж, нийгмийн баталгаагаар хангах, ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах болон зураг төслийн баримтыг хүлээн авах, нягтлан шалгалт хийхэд мэргэжлийн туслалцаа үзүүлэх, цахим сангийн ажилтнуудад дадлагажуулах сургалт зохион байгуулах, Төрийн архивын программыг байгууллагын архивын программтай холбох, сайжруулах, Тоо бүртгэлийн нэгдсэн системд мэдээ оруулахад арга зүйгээр хангаж ажиллах зэрэг саналуудыг ирүүлсэн байна.

Тайлан, мэдээ ирүүлэхдээ дараах анхаарах зүйл байна.

-Тайлан, мэдээг хугацаанд нь ирүүлж байх

-Ирүүлсэн тоон мэдээлэл, тайланд дурдсан байдал зөрүү байх. /Зарим архивуудын тоон мэдээлэл нь өмнөх онд ирүүлсэн мэдээллээс зөрүүтэй байна/

-Тайлангийн бүтэц, үг үсгийн алдаа, найруулгад анхаарах, баримт бичгийн стандартыг мөрдөх

Чиглэл, зөвлөмж

1. Нийт төрийн архивуудын хэмжээнд орон тоо дутагдалтай учир лавлагаа, мэдээллийн үйлчилгээ, баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагаанд ихэнх цаг хугацааг зарцуулж, архивын бусад үйл ажиллагаанд хүрч ажиллаж чадахгүй байдал үүсдэг тул байгууллагын удирдлагууд архивын орон тоог нэмэгдүүлэх талаар анхаарах
2. Энэхүү хяналт-шинжилгээний тайланд дурдсан анхаарвал зохих асуудлуудыг хэрэгжүүлэхдээ анхаарч ажиллах
3. Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан ажлын биелэлтэд хяналт тавьж ажиллах
4. Тайлан, мэдээ болон АЕГ-аас хүргүүлсэн албан бичгийн хариуг журам, албан бичигт заасан хугацаанд нь бүрэн гаргаж ирүүлж байх. Архивын дарга /эрхлэгч/ өөрсдөө тайлангаа бичиж, гарын үсэг, тамга /тэмдэг/-аар баталгаажуулж ирүүлж байх
5. Хууль зүй дотоод хэргийн сайдаас аймаг, нийслэл холбогдох агентлагийн даргатай байгуулсан гэрээнд архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр тусгасан ажлын хэрэгжилтийг хангаж ажиллах, гэрээний биелэлтийг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор ирүүлж байх
6. Архивын баримтын нийт тоог хэмжээг тодорхой гаргах, үүнээс цахим хэлбэрт шилжүүлэх шаардлагатай баримтын тоог тодорхой болгох /Тоон мэдээ авахад мэдээлэл зөрүүтэй ирэх байдал давтагддаг/
7. Архивын тухайн жилийн төлөвлөгөөний биелэлтийг Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжээрээ дүгнүүлэн ирүүлж байх

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС